

**“ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ”
ОРА-2017/НА-06**



Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтын дагуу өгсөн зөвлөгөө, сургалтуудын дүнд байгууллагууд мэдээллээ нэгдсэн цахим хуудсанд байршуулж байгаа хэдий ч мэдээлж буй мэдээллээ сайтар шалгах, хуулийн хүрээнд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан, мэдээллийг хуулинд заагдсан цаг хугацаанд нь бүрэн, зөв оруулж хэвших шаардлагатай байна.

**Орхон аймаг
2017 он**

Аудитыг гүйцэтгэсэн:

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газрын дарга,
тэргүүлэх аудитор:
Ц.Нармандах

Аудитын менежер:
Б.Эрдэнэ

Аудитор:

О.Дашжамц
В.Жавзмаа
Г.Оргилмөрөн
Б.Буян-Ундрах
Т.Болормаа
Б.Бямбатогтох

2017 оны 11 дүгээр сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70357955, 70350757
дугаарын утас,
70359826 дугаарын
факсаар харилцана уу.

Уг тайланг УАГ-ын веб
сайтаас үзнэ үү.

www.audit.mn

Хаяг: Орхон аймаг
дахь төрийн аудитын
газар

Баян-Өндөр сум,
Хүрэнбулаг баг,
Нутгийн удирдлагын
ордон

Агуулга

Товчилсон үгсийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Бүлэг 1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд бүрэн хамрагдсан хэдий ч нийт байгууллагуудын 81.1 хувь нь мэдээлэл хүргэх хэлбэрийг бүрэн баримталсан байна.	
• Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна.....	5
• Байгууллагуудын 81.1 хувь нь шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталж мэдээлсэн байна.....	5
Бүлэг 2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг 87.2 хувьтай мэдээлсэн байна.	
• Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь 90.8 хувьтай мэдээлсэн байна.....	6
• Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд 7 хоногийн дотор мэдээлэх мэдээллийг 83.7 хувьтай мэдээлсэн байна.....	7
• “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, мэдээллийг хуульд заасан хугацаа хоцроож мэдээлсэн байна.....	9
• Орхон аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5-т хамаарах хуулийн дагуу мэдээлэх ёстой байгууллагууд нь мэдээлсэн хэдий ч хуулийн шаардлагыг хангахгүй байна.....	9
Бүлэг 3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа ч иргэдийн Төлөөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хурлын хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	
• Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.....	10
• Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.....	10
• Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд ажлын тайлан дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг тусгаагүй байна.....	11
• Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны мэдээллийг иргэд ашиглаж, хяналт тавьдаг ба холбоотой санал хүсэлт, гомдол гардаггүй байна.....	11
Бүлэг 4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг 100 хувьтай, зөвлөмжийг 83 хувьтай хэрэгжүүлсэн байна.	
• Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага 100 хувьтай биелжээ.....	11
• Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүд 83 хувьтай биелжээ.....	11
Дүгнэлт	12
Зөвлөмж	12

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ		Улсын Их Хурал
ҮАГ		Үндэсний Аудитын газар
ЗДТГ		Засаг даргын тамгын газар
ИТХ		Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИНХ		Иргэдийн Нийтийн хурал
ТӨХК		Төрийн өмчит хувьцаат компани
ААН		Аж ахуйн нэгж
ТББ		Төрийн бус байгууллага
ӨЭМТ		Өрхийн эрүүл мэндийн төв
ОНӨААТҮГ		Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УЦУОШГ		Ус цаг уур, орчны шинжилгээний газар
ХЭДС		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХХҮГ		Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
МСҮТ		Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
ЭМНДХ		Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 02 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөө, Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлийн хүрээнд аудит хийнэ. Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан, бүрэн хамрагдсан эсэх,
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх,
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх,
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад Шилэн дансны тухай хуульд хамаарах хуулийн этгээдүүдийн 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгалаа.

Уг аудитад дараах нийт 135 байгууллагуудыг хамрууллаа. Эдгээр нь:

- Орон нутгийн өмчит хуулийн этгээд – 75,
- ОНӨААТҮГ – 5,
- Төрийн өмчит хуулийн этгээд – 27,
- Төрийн өмчит үйлдвэрийн газар – 4,
- Эрдэнэт үйлдвэр ХХК,
- ӨЭМТ – 9,
- Хувийн сургууль, цэцэрлэг – 14.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дүгээр стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах, иргэд, хэрэглэгчдээс судалгаа авах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол улсын 2016 оны төсвийн тухай хууль,

- Монгол улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль,
- Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль,
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”,
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2017 оны 10 дугаар сарын 24-нээс, талбарын ажлыг 2017 оны 10 дугаар сарын 31-нээс, тайлагналын үе шатны ажлыг 11 дүгээр сарын 10-наас эхлэн, тайланг 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, Тэргүүлэх аудиторoor баталгаажуулж, 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор УАГ-т хүргүүллээ.

Үндсэн мэдээлэл:

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 7 төрлийн мэдээлэл, 3.1.2-т заасан төрийн өмчит үйлдвэрийн газар 7 төрлийн мэдээлэл, 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 3 төрлийн мэдээлэл, 3.1.4, 3.1.5-т заасан байгууллагууд 1 төрлийн мэдээлэл тус бүр оруулахаар хуульчилжээ.

Аудитад хамрагдсан 135 байгууллага нь Шилэн дансны цахим хуудсанд 94.1 хувьтай хамрагдаж, 87.2 хувьтай мэдээлсэн байна. Аудитаар нийт 33 албан шаардлага, 6 зөвлөмж өгөгдлөө.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн
хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан эсэх

Бүлэг 1

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд бүрэн хамрагдсан хэдий ч нийт байгууллагуудын 81.1 хувь нь мэдээлэл хүргэх хэлбэрийг бүрэн баримталсан байна.

1.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хуулийн үйлчлэлд хамаарахаар зааснаас Орхон аймагт төрийн өмчит хуулийн этгээд 31 /улсын төсөвт болон яам, агентлагийн ТЕЗ-ийн/, орон нутгийн өмчит 76 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 100 хувь хамрагджээ.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т төрийн өмчит үйлдвэрийн газрууд хуулийн үйлчлэлд хамаарахаар заасны дагуу төрийн өмчит ЭДЦС ТӨҮГ, ЭБЦТС ТӨҮГ, ОРХОН АЗЗА ТӨҮГ-ууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 100 хувь хамрагджээ.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани хуулийн үйлчлэлд хамаарахаар заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ХХК шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдсан байна.

Орхон аймагт 2016 оны 4-р улирал болон 2017 оны эхний 3 улирлын байдлаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ажил гүйцэтгэсэн нийт 180 аж ахуй нэгж байгаагаас шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2 компани өөрийн цэстэй болсон байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгч ТББ-1, ӨЭМТ-9, хувийн сургууль, цэцэрлэг-14 байдаг ба шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 8 ӨЭМТ, 7 хувийн сургууль, цэцэрлэг хамрагдаж бусад байгууллагууд нь хамрагдаагүй, хуулийн 6-р зүйлийн 6.9 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд өөрийн цэсгүй 178 компани, 1 ТББ нь шилэн дансны цахим хуудас нээлгээгүй хэдий ч санхүүжилтийг олгосон талаарх мэдээллийг аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд хамруулж мэдээлсэн байна.

1.2 Байгууллагуудын 81.1 хувь нь шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталж мэдээлсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдсан байгууллагуудын хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтны нэр, холбоо барих утасны дугаар зэрэг мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг шалгахад 8 байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нар өөрчлөгдсөн байтал мэдээллийг шинэчлээгүй зөрчил илэрснийг аудитын явцад засаж шинэчлүүлээ. Тухайлбал: БСУГ-ын нягтлан бодогч, ЭМГ-ын дарга, БОЭТ-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч, Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ-ын захирал, Хөх монгол цогцолбор ОНӨААТҮГ-ийн захирал, нягтлан бодогч нар өөрчлөгдсөн байтал мэдээллийг шилэн дансанд шинэчлээгүй байлаа.

Нийт хөрөнгө оруулалтын мэдээллээ Төсвийн ерөнхийлөн захирагчийн “Орхон аймаг” гэсэн цэсэнд мэдээлсэн ба уг цэсэнд мөн Засаг даргын нөөц сан, хуваарилагдаагүй

сан, Эрдэнэт сан зэрэг олон дансны мэдээлэл нэг дор мэдээлэгдэж байгаа нь харахад замбараагүй, ойлгомжгүй байна. Эдгээр сангууд тус бүрт тусдаа цэс үүсгэж мэдээлэх нь иргэдэд ил тод хяналт тавихад хялбар болохоор байна.

Мөн ТЕЗ-ийн цахим хуудсанд хуулийн 3.1.4, 3.1.5-т хамаарах ажил гүйцэтгэсэн ААН, ТББ-уудын санхүүжилтийн мэдээг мэдээлсэн хэдий ч зөвхөн нийт санхүүжилтийн дүнг мэдээлсэн буюу нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээлэл тус бүрийг улирал бүр маягтын дагуу мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.9-д заасан “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд Орхон аймгийн Орхон аймаг-сум гэсэн байршлын алдаатай цэс байгаа ба үүнд Баян-Өндөр, Жаргалант сумын 14 байгууллага байгаа алдаатай байна.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан мэдээллийн самбар байгууллага бүрт байршиж, тухайн мэдээллийг байнга шинэчилж байхаар хуульчилсан боловч 7 байгууллага мэдээллийн самбар байршуулаагүй байна. Тухайлбал: Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар зэрэг байгууллагууд мэдээллийн самбар байршуулаагүй байлаа.

**Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар**

**Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны
мэдээллийг бүрэн мэдээлж байна уу?**

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг 87.2 хувьтай мэдээлсэн байна.

Бүлэг 2

2.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн үйлдвэрийн газрууд шилэн дансны мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь 90.8 хувьтай мэдээлсэн байна.

Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасны дагуу нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ байршуулсан 111 байгууллагын мэдээллийг холбогдох тайлан, НББ-ийн журнал, анхан шатны баримтуудтай тулган шалгахад:

- 42 байгууллага бүрэн байршуулсан,
- Дараа жилийн төсвийн төслийг 23 байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг 21, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 26 байгууллага мэдээлээгүй,

- Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг 33 байгууллага мэдээлээгүй байна.

Байгууллагуудын хамгийн өндөр хувьтай мэдээлсэн мэдээлэл нь төсвийн гүйцэтгэл 93.5 хувьтай, хамгийн бага хувьтай мэдээлсэн мэдээлэл нь төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг 70 хувьтай мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй, нийт 122 төрлийн мэдээллийг хуулийн дагуу мэдээлээгүй 33 байгууллагад албан шаардлага хүргүүлээ. Тухайлбал:

- “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын 2017 оны зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар, дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан мэдээлээгүй,
- 21-р цэцэрлэг нь жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг тодорхой бичээгүй, тухайн жилийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэх мэдээллийг аудитаар тулган баталгаажуулах үед байршуулаагүй байсан ба хуулийн хугацаанаас хоцроож мэдээлсэн.
- Сэлэнгэ голын сав газрын захиргаа нь тухайн жилийн батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, дарга, нягтлан бодогч өөрчлөгдсөн байтал нэгдсэн цахим хуудсанд байрлах мэдээллүүдийг шинэчлээгүй, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн хэтрэлт, хэмнэлт түүний шалтгааны тайлбарыг тодорхой бичээгүй зэрэг зөрчлүүдтэй байгууллагууд байна.

2.2 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн үйлдвэрийн газрууд 7 хоногийн дотор мэдээлэх мэдээллийг 83.7 хувьтай мэдээлсэн байна.

Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ байршуулсан 111 байгууллагын 9 төрлийн мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт		2016 оны 10 сарын байдлаар	2017 оны 10 сарын байдлаар
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний тоо	823	564
	Үүнээс: Мэдээлсэн гүйлгээний тоо	799	427
	Нийт мэдээлсэн мөнгөн дүн (сая. төг)	10,928.2	5,240.8
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний тоо	24	137
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний мөнгөн дүн	64.8	3,972.0
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний тоо	1,406	1,253
	Үүнээс: Мэдээлсэн гүйлгээний тоо	1,367	947
	Нийт мэдээлсэн мөнгөн дүн (сая. төг)	61,388.6	27,576.9
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний тоо	39	306
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний мөнгөн дүн	522.9	9,912.5
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний тоо	1,533	2,104
	Үүнээс: Мэдээлсэн гүйлгээний тоо		

		1,328	1,583
	Нийт мэдээлсэн мөнгөн дүн (сая. төг)	83,063.1	49,465.7
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний тоо	205	521
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний мөнгөн дүн	9,103.5	17,512.8
Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл	Нийт шийдвэрийн тоо	1,132	1,536
	Үүнээс мэдээлсэн тоо	1,050	1,169
	Мэдээлсэн шийдвэрийн мөнгөн дүн (сая.төг)	6,404.6	7,675.7
	Мэдээлээгүй тоо	82	367
	Мэдээлээгүй шийдвэрийн мөнгөн дүн (сая.төг)	291.1	1,730.6

- Тендерт оролцсон 995 оролцогчийн 616-г цахим хуудсаар мэдээлсэн буюу мэдээлсэн хувь 61.9% байна.
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг 564 мэдээлэл байршуулахаас 5240.8 сая төгрөгийн 427 худалдан авалтыг мэдээлж, 3972.0 сая төгрөгийн 137 худалдан авалтыг мэдээлээгүй байна. Мэдээлсэн хувь 76.1%.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1253 мөнгөн гүйлгээг мэдээлэхээс 947 удаагийн 27576.9 сая төгрөгийн гүйлгээг мэдээлж, 306 удаагийн 9912.5 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна. Мэдээлсэн хувь 74.4%.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2104 мөнгөн гүйлгээг мэдээлэхээс 1583 удаагийн 49465.7 сая төгрөгийн гүйлгээг мэдээлж, 521 удаагийн 17512.8 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байлаа. Мэдээлсэн хувь 74.8%.
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 1536-г мэдээлэхээс 7675.7 сая төгрөгийн 1169 шийдвэрийг мэдээлж, 1730.6 сая төгрөгийн 367 шийдвэрийг мэдээлээгүй байна. Мэдээлсэн хувь 75.9%.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй, нийт 15200.3 сая төгрөгийн гүйлгээний мэдээллийг хуулийн дагуу мэдээлээгүй 26 байгууллагад албан шаардлага хүргүүлээ. Тухайлбал:

- Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг 45 удаагийн 3043.4 сая төгрөг мөнгөн гүйлгээ, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 2.3 сая төгрөгийн 4 шийдвэрийг мэдээлээгүй,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 23,2 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээг, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 298,8 сая төгрөгийн 4 мөнгөн гүйлгээ, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр,

хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 210,0 сая төгрөгийн 2 шийдвэрийг мэдээлээгүй,

- Нийгмийн даатгалын сан нь цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 3398.4 сая төгрөгийн 11 гүйлгээг мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2610.6 сая төгрөгийн 199 гүйлгээг мэдээлээгүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

2.4 “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, мэдээллийг хуульд заасан хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийг хуулийн 6.8-д заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэхийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ХХК нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2016 оны 4-р улирал болон 2017 оны эхний 3 улирлын байдлаар зөвхөн “Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл”-ийг оруулсан байх ба эхний 7 сарын мэдээ нь хугацаа хоцроож байршуулжээ.

Эрдэнэт үйлдвэр ХХК-д 2016 оны 4-р улирал болон 2017 оны эхний 3 улирлын байдлаар нийт 29,889.6 сая төгрөгийн 62 тендер явагдсан байна.

Үүнээс нийт 4625.4 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 18 тендерийг мэдээлсэн ба эдгээр тендерийн шалгарсан 18, шалгараагүй 36, нийт 54 оролцогчийн мэдээллийг байршуулсан ч хуулиар заасан хугацааг хоцроосон байна. Үлдсэн 25264.2 сая төгрөгийн 44 тендер, эдгээрт шалгарсан 44, шалгараагүй 216 оролцогчийн мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.8-д заасан “Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.8.1.тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр; 6.8.2.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; 6.8.3.төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Концессийн мэдээлэл, бонд, зээл, өрийн бичиг, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төрийн хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалттай холбоотой мэдээлэл гараагүй гэж мэдээлжээ.

Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 6.8.2-т заасан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө /бүтэн жилээр/, тайлан, 6.10-т заасан нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл /тухай бүр/-ийг огт мэдээлээгүй байна.

2.5 Орхон аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5-т хамаарах байгууллагууд нь мэдээллээ цахим хуудсанд байршуулсан боловч хуулийн шаардлагыг хангахгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5, 6 дугаар зүйлийн 6.9-д хамаарах 180 компани, 1 ТББ, 9 ӨЭМТ, 14 хувийн сургууль, цэцэрлэг байна.

Дээрх 204 байгууллагаас өөрийн байгууллагын цахим хуудсандаа мэдээллээ бүрэн байршуулсан 6, дутуу байршуулсан 7 байгууллага байна.

Үлдсэн 191 байгууллага нь шилэн дансны цахим хуудас нээлгээгүй хэдий ч санхүүжилтийг олгосон талаарх мэдээллийг аймгийн ТЭЗ-ийн шилэн дансны цахим

хуудас, erdenet.mn болон facebook хуудсаар мэдээлжээ. Ийнхүү мэдээлэхдээ нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээлэл тус бүрийг улирал бүр маягтын дагуу мэдээлээгүй байгаа нь хуулийн 6.9 дэх заалттай нийцэхгүй байна.

ӨЭМТ болон хувийн сургууль, цэцэрлэгүүд нийт 23 байгууллагаас 3 нь буюу Үйлс бадрах ӨЭМТ, Ачлалт нар ӨЭМТ, Мэндцэцэн ӨЭМТ-үүд мэдээллийн самбартай хэдий ч тэдгээр байгууллагууд нь тухайн самбартаа шилэн дансны мэдээллийг хуулийн дагуу хугацаанд нь мэдээлээгүй байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн үү?

Бүлэг 3

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа ч иргэдийн Төлөөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хурлын хөндлөнгийн хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2016 оны 11 сарын 16-ны өдрийн 124 дүгээр тогтоолд “Төсвийн оновчтой бодлого-иргэний оролцоо” сарын ажлын хүрээнд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явц, байдалтай танилцах ажлыг зохион байгуулахаар тусгасан хэдий ч хяналтыг тогтмол хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг Иргэдийн Нийтийн Хурал хэрэгжүүлэх ёстой боловч хяналт хэрэгжүүлсэн ямар нэгэн баримт материал байхгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 8-р зүйлийн 8.1 дэх заалттай нийцэхгүй байна.

3.2 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлжээ.

Хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлэхээр заасан бөгөөд Орхон аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналтыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлж байна. Тус алба нь 2016 оны 4 дүгээр улиралд 76, 2017 оны 1 дүгээр улиралд 75, 2 дугаар улиралд 76 байгууллагын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийж, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд тайланг хүргүүлжээ. Уг шалгалтаар 4 зөвлөмж, 6 байгууллагад хариуцлага тооцох албан бичиг хүргүүлсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас орон нутгийн төсвийн байгууллагууд болон ерөнхий боловсролын сургууль, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын удирдах ажилтан, дотоод хяналтын ажилтан, нягтлан бодогч нарт шилэн дансны хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллах үүднээс шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулах чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, 76 байгууллагын ажилтан, албан хаагчдыг хамруулсан байна. Уг сургалтын үр дүнд мэдээллийг иж бүрэн мэдээлэх байдал 25 хувиар нэмэгдсэн байна.

Улирал болгон шалгалт явуулж, сургалтанд хамруулж байгаа хэдий ч аудитын явцад хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг 87.2 хувьтай мэдээлж, мэдээлэл хүргэх хэлбэрийг 81.1 хувьтай баримталж байгаа дүн гарсан. Иймд эрх бүхий албан тушаалтнуудын хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.

3.3 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд ажлын тайлан дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг тусгаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг Орхон аймгийн ТЭЗ-ийн дотоод хяналтаар өөрийн чиг үүрэгт хамаарах 76 байгууллагад хяналт тавьсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчит 111 байгууллагаас 95 байгууллагын удирдах албан тушаалтнуудтай байгуулсан үр дүнгийн гэрээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгаагүй байна. Тухайлбал: Орон нутгийн өмчийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Сум дундын ойн анги зэрэг байгууллагууд байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 8-р зүйлийн 8.4-т заасан “Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно” заалттай нийцэхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах 111 байгууллагаас 5 байгууллагын удирдлага нь шилэн дансны мэдээллийг хариуцсан ажилчидтай үр дүнгийн гэрээ байгуулахдаа шилэн дансны талаар тусгаж өгсөн байна.

Цаашид байгууллагын албан хаагчид нь шат шатны удирдлагуудтай байгуулах үр дүнгийн гэрээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зүйл заалт оруулан, үр дүнг жил бүр үнэлж дүгнэж байх шаардлагатай байна.

3.4 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны мэдээллийг иргэд ашиглаж, хяналт тавьдаг ба холбоотой санал хүсэлт, гомдол гардаггүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд тухайн байгууллагын мэдээлэлтэй хэдэн хүн орж танилцсаныг мэдээлдэггүй учир иргэд хэрхэн ашиглаж, хяналт тавьдаг эсэхийг нотлох боломжгүй байна. Орхон аймаг дахь Захиргааны хэргийн шүүх болон ЗДТГ-ын санал хүсэлт, гомдол хүлээн авдаг 70353511 утсанд Шилэн дансны тухай хуультай холбоотой гомдол ирээгүй байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг
хэрэгжүүлсэн үү?

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг 100 хувьтай, зөвлөмжийг 83 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Бүлэг 4

4.1 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага 100 хувьтай биелжээ.

Өмнөх аудитаар аймгийн СТСХ-т өгсөн “Мэдээллээ бүрэн байршуулаагүй, цахим хуудас нээлгээгүй, мэдээллийн өөрчлөлтийг шинэчлээгүй” гэсэн албан шаардлага өгөгдсөн.

Хэрэгжилт: Төрийн аудитын байгууллагад 2016 оны 6 сарын 27 ний өдрийн 6/1778 тоот албан бичгээр албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дэлгэрэнгүйг нотлох баримтаар ирүүлсэн болно.

4.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүд 83 хувьтай биелжээ.

Өмнөх аудитаар дараах зөвлөмжүүд өгөгдсөн байна. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу хяналт хэрэгжүүлж, албан тушаалтнуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлэн ажиллах.

Хэрэгжилт: Аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас улирал бүр Шилэн дансны тухай хуулийн талаар шалгалт явуулж, тодорхой үр дүн гаргаж ажилласан байна.

2. Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээг гүйцэтгэгч этгээдийг нийт

төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн талаарх мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулж хэвшүүлэх.

Хэрэгжилт: 9 ӨЭМТ, 7 хувийн сургууль, 7 хувийн цэцэрлэг, 7 ТББ болон ААН-үүд шилэн дансны цахим хуудсанд нэгдэн мэдээллээ оруулж байна, ТЕЗ-ийн шилэн дансны цэсээр нийт олгосон санхүүжилтийг мэдээлж байна.

3. Шинээр үүсгэн байгуулагдсан Нийтлэг үйлчилгээний албаны цахим хуудсыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нээлгэж, мэдээллүүдийг бүрэн байршуулах.

Хэрэгжилт: Нийтлэг үйлчилгээний албаны цахим хуудсыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нээж, мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4. Байгууллагуудын эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдолд нэгдсэн цахим хуудсанд байрлах мэдээллийг шинэчлэх

Хэрэгжилт: Эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн 8 байгууллагын мэдээллийг шинэчлээгүй байна.

5. Шинээр томилогдсон төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт Шилэн дансны болон холбогдох хууль эрхийн сургалт зохион байгуулж, удирдлагаар хангах.

Хэрэгжилт: Аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас шинээр томилогдсон 10 байгууллагын удирдах ажилтан, дотоод хяналтын ажилтан, нягтлан бодогч нарт шилэн дансны хууль, тогтоомжийн хэрэгжилт, цахим хуудсанд мэдээлэл оруулах чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан байна.

6. Аймаг, сумын ИТХ, иргэдийн Нийтийн хурал шилэн дансны тухай хуулийн 8.1-д заасан хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллах.

Хэрэгжилт: Аймгийн ИТХ-ын 2016 оны 11 сарын 16-ны өдрийн 124 дүгээр тогтоолын дагуу “Төсвийн оновчтой бодлого-иргэний оролцоо” сарын ажилд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явц, байдалтай танилцах ажлыг зохион байгуулахаар болсон байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Дүгнэлт, зөвлөмж

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд бүрэн хамрагдсан хэдий ч нийт байгууллагуудын 81.1 хувь нь мэдээлэл хүргэх хэлбэрийг бүрэн баримталсан байна
2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг 87.2 хувьтай мэдээлсэн байна.
3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа ч иргэдийн Төлөөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хурлын хөндлөнгийн хяналт хэрэгжүүлээгүй байна.
4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг 100 хувьтай, зөвлөмжийг 83 хувьтай хэрэгжүүлсэн.

Дээрхээс үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтын дагуу өгсөн зөвлөгөө, сургалтуудын дүнд байгууллагууд мэдээллээ нэгдсэн цахим хуудсанд байршуулж байгаа хэдий ч мэдээлж буй мэдээллээ сайтар шалгах, хуулийн хүрээнд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан, мэдээллийг хуулинд заагдсан цаг хугацаанд нь бүрэн, зөв оруулж хэвших шаардлагатай байна гэсэн дүгнэлт өгч байна.

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доорх албан тушаалтнуудад зөвлөж байна.

Орхон аймгийн Засаг даргад:

- Үр дүнгийн гэрээ болон, ажлын тайлан дүгнэхдээ Шилэн дансны тухай хуулийн 8.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах,
- Шилэн дансны тухай хуулийн 6.9 дэх заалтыг баримтлан хуулийн 3.1.4, 3.1.5-т заасан хуулийн этгээдийн мэдээллийг байршуулж хэвшүүлэх,
- Орон нутгийн хөгжлийн сан болон бусад тусгай сангуудыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тусдаа цэстэй болгох,
- Байгууллагуудын мэдээллийн самбар болон шилэн дансны цахим хуудсанд мэдээлж байгаа мэдээллийн хэлбэрийг журам, стандартын дагуу байлгах.

Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлагуудад:

- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу мэдээллийг стандартын дагуу мэдээлэх.

Сумдын ИТХ-д:

- Сумын ИТХ, иргэдийн Нийтийн Хурал шилэн дансны тухай хуулийн 8.1-д заасан хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллах.

МЭДЭГДЭЛ:

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 04 дүгээр сарын 01-ний дотор ирүүлэхийг мэдэгдье.

САНАЛ:

Шилэн дансны цахим хуудсыг сайжруулах, иргэдэд ойлгомжтой, ашиглахад хялбар байх үүднээс тухайн байгууллагын мэдээллийг хэдэн хүн орж харсан тоог мэдээлдэг, мөн хэрэглэгчид сэтгэгдэл үлдээдэг болгох, цахим хуудаснаас pdf файлыг заавал татаж авахгүйгээр, шууд танилцаж болдог болгох шаардлагатай байна.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

О.ДАШЖАМЦ
В.ЖАВЗМАА
Б.БУЯН-УНДРАХ
Т.БОЛОРМАА
Б.БЯМБАТОГТОХ
Г.ОРГИЛМӨРӨН

О.Даштүүлэг
2017.11.28
[Signature]


**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ**
61000 Орхон аймаг, Амарын талбай УБД-20/26
Утас: 70350483, Факс: 70352631
2017.11.28 № 552
төний _____ -ны № _____ -т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт нийцлийн
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн
төсөлд тусгах саналгүй болно.

Хавсралт: 4 хуудас

ДАРГА [Signature] Н.ПҮРЭВЛХАГВА



C:\My documents\toor\A5
001000000766



**ОРХОН АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА**

61000 Баян-Өндөр сум, Орхон, Залуучуудын гудамж-1
УБД-4397363, Захирааны III байр, 2 давхарт
Утас/Факс: 70359856, E-mail: sankhuu_audit_or@yahoo.com

2017.11.24 № 215
талай 2017.11.20 -ны № 207

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Б.Эрдэнэ, О.Дамдинсүрэн,
аудит хийсэн байн

2017.11.24

Тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай

Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна.

1. Аймгийн Засаг даргад хандан ирүүлсэн шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийн дүн, түүнд илэрч буй алдаа зөрчилд аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарахгүй улсын төсөвт байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчийн оролцоотой хувьцаат компаний шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар дүгнэлт орсон байна. Иймд аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах байгууллагуудад хамаарах шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтэнд дүгнэлт гаргаж, улсын болон төрийн өмчит үйлдвэрийн газрын шилэн дансны хэрэгжилтэнд аймгийн Засаг даргын зүгээс хууль тогтоомжийн хүрээнд ямар түвшинд, ямар арга хэмжээ авч ажиллах талаар тодорхой тусгаж өгнө үү.
2. Тайлангийн төслийн 3.3-т "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг Орхон аймгийн ТЭЗ-ийн дотоод хяналтаар 76 байгууллагад түүвэрлэн шалгасан байна" гэсэн байна. Манай байгууллагын хувьд аймгийн Төсвийн багцад хамаарах 76 байгууллага байдлыг улирал бүр бүгдийг хамруулан хяналт тавьсан бөгөөд улсын төсөвт болон төрийн өмчит байгууллагын шилэн дансны хэрэгжилтэнд тухайн яам, агентлагийн дотоод аудитын нэгж хяналт тавих үүрэгтэй болно. Иймд "түүвэрлэн шалгасан" гэснийг "76 байгууллагад хяналт тавьсан байна" гэж өөрчлөх саналтай байна.
3. Тайлангийн төслийн мөн 3.3-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдах албан тушаалтнуудтай байгуулсан үр дүнгийн гэрээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгаагүй..." гэсэн байна. Аймгийн Засаг дарга 2017 онд байгууллагын дарга, удирдлагуудтай хийсэн үр дүнгийн гэрээнд шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг оруулж өгсөн. Үр дүнгийн гэрээ, контрактад шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлт тусгаагаагүй төрийн болон орон нутгийн өмчит ямар хуулийн этгээдүүд байгаа тодорхой дурьдаж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн сайжруулах талаар бодитой дүгнэлт өгнө үү.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.САЙЗМАА



000476

Холбогдох байгууллагуудаас ирсэн саналын дагуу тайлангийн төслийн 3.3-т “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг Орхон аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналтаар 76 байгууллагад түүвэрлэн шалгасан байна” гэсэн байсныг “Орхон аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналтаар өөрийн чиг үүрэгт хамаарах 76 байгууллагад хяналт тавьсан байна” болгож, төслийн мөн 3.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдах албан тушаалтнуудтай байгуулсан үр дүнгийн гэрээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгаагүй” гэсэн байсныг “Төрийн болон орон нутгийн өмчит 111 байгууллагаас 95 байгууллагын удирдах албан тушаалтнуудтай байгуулсан үр дүнгийн гэрээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгаагүй байна” болгож өөрчиллөө.

Хавсралт № 1

Нийцлийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

/ сая төгрөгөөр/

Д/Д	Зөрчлийн товч утга	Зөрчил хариуцагч байгууллага	хариуцагч		Зөрчил	Алдаа
			Албан тушаал	Нэр		
1	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	УЦУОШГ	Дарга Нягтлан бодогч	Я.Тунгалаг Б.Өлзиймаа		141.2
2	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	ХЭДС	Дарга Нягтлан бодогч	Х.Эрдэнэбат О.Саранчимэг		532.0
3	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	Сэлэнгэ голын сав захиргаа	Дарга Нягтлан бодогч	М.Чулуунзагд Н.Эрдэнэ		83.6
4	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	ХХҮГ	Дарга Нягтлан бодогч	Х.Эрдэнэбат П.Наран		404.5
5	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	БОЭТ	Захирал Нягтлан бодогч	Б.Батсүх Э.Баасанжаргал		3,045.7
6	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	Хөх монгол цогцолбор ОНӨААТҮГ	Захирал Нягтлан бодогч	Ж.Батбаатар Б.Долгормаа		
7	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	Зэвсэгт хүчний 110 дугаар анги	Захирагч Нягтлан бодогч	Л.Балдан-Очир Ч.Самданжамц		
8	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	Зэвсэгт хүчний 186 дугаар анги	Захирагч Нягтлан бодогч	Д.Жигжидсүрэн Г.Мөнхбаяр		
9	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	“Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК	Захирал Нягтлан бодогч	Д.Бүүвэйбаатар Е.Чулуунбат		
10	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	6-р цэцэрлэг	Эрхлэгч Нягтлан бодогч	Э.Ганцэцэг Г.Цэцгээхүү		130.5
11	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	20-р цэцэрлэг	Эрхлэгч Нягтлан бодогч	Р.Алтантуяа А.Алтанзул		38.1
12	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	4-р цэцэрлэг	Эрхлэгч Нягтлан бодогч	Ж.Минж Ц.Оюунцэцэг		475.5
13	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	2-р сургууль	Захирал Нягтлан бодогч	Г.Баяраа Ж.Эрдэнэчимэг		67.3
14	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	7-р сургууль	Захирал Нягтлан бодогч	Ц.Одгэрэл Р.Даваажаргал		23.9

15	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	11-р цэцэрлэг	Эрхлэгч Нягтлан бодогч	Д.Эрдэнэчимэг Х.Болор-Эрдэнэ		81.7
16	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	8-р сургууль	Захирал Нягтлан бодогч	Д.Бат-Эрдэнэ П.Тунгалагтамир		488.7
17	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	13-р сургууль	Захирал Нягтлан бодогч	А.Сэлэнгэбаатар Я.Анхболд		275.9
18	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	14-р сургууль	Захирал Нягтлан бодогч	П.Амгалан А.Лхагвагэрэл		192.8
19	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	15-р сургууль	Захирал Нягтлан бодогч	М.Галбаатар М.Энхтуяа		107.0
20	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	17-р сургууль	Захирал Нягтлан бодогч	Ц.Болдсүх Д.Жаргалсүрэн		121.0
21	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	“Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ	Дарга Нягтлан бодогч	Х.Төгсбаяр Ч.Чинцэцэг		
22	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	“Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ	Дарга Нягтлан бодогч	Г.Энхбаяр Д.Эрдэнэтуул		533.3
23	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	10-р цэцэрлэг	Эрхлэгч Нягтлан бодогч	Т.Энхмаа Д.Отгонжаргал		
24	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	19-р цэцэрлэг	Эрхлэгч Нягтлан бодогч	В.Бадамгарав Б.Дулам		
25	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	ЭМНДХ	Дарга Нягтлан бодогч	Б.Анар Г.Даваасүрэн		622.3
26	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	Нийгмийн даатгалын сан	Дарга Нягтлан бодогч	Б.Анар Г.Даваасүрэн		6009.0
27	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	4-р сургууль	Захирал Нягтлан бодогч	Д.Доржханд Д.Саранцэцэг		206.9
28	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	21-р цэцэрлэг	Эрхлэгч Нягтлан бодогч	Р.Цэвэлсүрэн Б.Дамба		36.4
29	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	Боловсрол, соёл урлагийн газар	Дарга Нягтлан бодогч	Ж.Бат-Амгалан М.Халиунаа		20.3
30	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	ХАА-н МСҮТ	Захирал Нягтлан бодогч	Н.Алтанцоож О.Жавхлан		78.9
31	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	Орхон МСҮТ	Дарга Нягтлан бодогч	Ч.Цэвэгмэд Б.Өлзийжаргал		456.6

32	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	Статистикийн хэлтэс	Дарга Нягтлан бодогч	Д.Эрдэнэчимэг Э.Мөнхзаяа		83.2
33	Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ бүрэн мэдээлээгүй.	ХББЗА ОНӨААТҮГ	Дарга Нягтлан бодогч	Б.Мөнхдалай П.Сувданзаяа		97.0
Нийт дүн						14,353.3

Акт, албан шаардлагыг хариуцагч байгууллагуудад эх хувиар хүргүүлсэн, зөрчлийг дэлгэрэнгүй тайланд тусгасан.